

ЯПОН ДАХЬ СОЛОНГОСЧУУД

Т.Амгалан*

“Zainichi Koreans” гэдэг үг нь юуны өмнө Японд амьдардаг хэдий ч Японы иргэн болоогүй солонгос хүмүүс гэсэн утга илэрхийлдэг. Энэ үг нь “Zainichi Kankokujin” буюу Япон дахь өмнөд солонгосчууд, “Zainichi Chosenjin” буюу Япон дахь хойд солонгосчууд хэмээх үгнүүдийн товчлол юм. Япон хэлээр “Zainichi” гэдэг үг нь “Японд үлдэх” гэсэн утга илэрхийлдэг. Жишээлбэл “Zainichi Gaikokujin” гэдэг нь “Японд амьдарч буй гадаад хүн” гэсэн утга илэрхийлдэг бол “Rainichi Gaikokujin” гэдэг нь “Японд айлчилж буй гадаад хүн” гэсэн утга илэрхийлдэг байна. Гэхдээ өнөөдөр “Zainichi” нь гэдэг үг нь юуны өмнө Солонгосын өвийг дагагч, Японд удаан хугацаагаар амьдарч буй солонгосчуудад хамаарагдах нэр томъёо болжээ. Японы цагаачлалын албаны статистик мэдээнээс үзвэл 2005 оны байдлаар Японд 600.000 орчим Зайничи солонгосчууд байсан бөгөөд 2010 он хүртэл энэ тоо нэг их өөрчлөгдөхгүй төлөвтэй байна. Өмнөд болон Хойд Солонгосын иргэд, Солонгосгаралтай эдгээр хүмүүс одоогийн байдлаар Японы хамгийн том үндэсний цөөнх буюу Японы хүн амын нэг хувийг бүрдүүлж байна.


Өнөөдрийн ихэнхи залуу Зайничи солонгосчууд Японд төрж, өссөн 4 үеийнхэн бөгөөд зөвхөн япон хэлээр ярьж, япон компанид ажиллаж, япон хүмүүстэй гэр бүл болох нь улам бүр нэмэгдэж байна. Тэдний зарим нь японы иргэн болж байгаа бөгөөд Японы Хууль зүйн яамны мэдээгээр жилд 10000 орчим солонгос хүн японы иргэн болдог байна. Эдний дунд хоорондоо гэр бүл болсон япон болон солонгос иргэдийн хүүхдүүд мөн цөөнгүй хувийг эзэлдэг аж. Үлдсэн хэсэг нь өөрсдийн солонгос (Choseon) үндэсээ өөрсдийн өв болгон хадгалах замыг сонгож байна. (Японы болон Өмнөд Солонгосын аль алиных нь харъяатын тухай хуулиар бол насанд хүрсэн хүн давхар харъяалалтай байхыг зөвшөөрдөг байна)

Японы харъяат болохоор хүсэлт гаргагчид

Он	Нийт хүсэлт гаргагчид	Зөвшөөрсөн				Татгалзан
		Нийт	Солонгос	Хятад	Бусад	
1996	14,944	14,495	9,898	3,976	621	97
1997	16,164	15,061	9,678	4,729	654	90
1998	17,486	14,779	9,561	4,637	581	108
1999	17,067	16,120	10,059	5,335	726	202
2000	14,936	15,812	9,842	5,245	725	215
2001	13,442	15,291	10,295	4,377	619	130
2002	13,344	14,339	9,188	4,442	709	107
2003	15,666	17,633	11,778	4,722	1,133	150
2004	16,790	16,336	11,031	4,122	1,183	148

* Т.Амгалан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Япон дахь солонгосчуудын тоо



Японы колоничлол

1910 онд Япон нь Солонгосыг эзлэн түрэмгийлж авахаас өмнө Японд амьдарч байсан солонгос хүмүүсийн тоо 790 орчим байсан, мөн тэдний ихэнхи нь оюутнууд байсан гэдэг нийтлэг ойлголт байдаг. Гэвч Кейзо Ямавакигийн хийсэн сүүлийн үеийн судалгаа 1910 оноос өмнө нилээд олон тооны солонгосчууд Японд ирсэн байсан гэдгийг тодруулжээ. Тэдгээр хүмүүс 1890-ээд оны сүүлийн хагасаас эхлэн Японд амттаны явуулын наймаачинаар эсвэл нүүрсний уурхай, төмөр замын барилга дээр ажиллаж байжээ.

Гэхдээ олон тооны солонгосчуудыг Япон руу цагаачлахад хүргэсэн явдал нь Японы колоничлол байсан бөгөөд 1910 онд Солонгосыг эзлэн түрэмгийлсний дараа Солонгос улс нь Японы эзэнт гүрний бодлогын нэгэн субъект болсон юм. 1910-1918 оны хооронд Японы Засгийн газар Солонгосын газар эзэмшигчдээс ихээхэн хэмжээний газар хураан авсан, улмаар 1920-1934 оны хооронд Японы эрх бүхий албан тушаалтнууд Солонгосын цагаан будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж, үүнийхээ үр дүнд хураан авсан ургацын ихэнхи хэсгийг Япон руу экспортлох болсон нь Солонгосчуудын дунд өлсгөлөн, ядуурлын шалтгаан болжээ. Үүнээс болж ихэнхи Солонгосчуудын амьдралын үндэс суурь нь уналтанд орсон бөгөөд олон солонгосчууд гэрт нь учирч буй өлсгөлөнгөөс гарахын тулд Япон руу хөдөлмөр эрхлэхээр явцгааж байлаа. Солонгосын хойгийн өмнөд хэсэг болох Kyongsang-do, Cholla-Do, Cheju-Do-ийн солонгосчууд Япон руу явцгааж байсан бол хойд хэсгийн Солонгосчууд нь өнөөгийн Хятадын зүүн хойд бүс нутаг болох хуучин Манжуур руу явцгааж байжээ.

Японд очсон Солонгосчууд япончуудын зүгээс хатуу ширүүн харьцаа, ялгаварлан гадуурхах үзэл, шудрага бус байдал болон олон асуудалтай тулгарсан юм. Жишээлбэл 1923 оны Кантогийн газар хөдлөлтийн дараа олон тооны солонгосчууд зөвхөн солонгос хүн байснаараа гал түймэр тавьж, гол ус хордуулж газар хөдлөлтийн дараах

нөхцөл байдлыг улам дордуулсан хэмээн буруутгагдаж, амиа алдаж байжээ. Гэсэн хэдий ч ажил хайн Япон руу ирэгсдийн тоо зогсолтгүй нэмэгдсээр л байлаа. Ихэнхи тохиолдолд эрэгтэй солонгосчууд гэр бүлээ орхин Япон руу ганцаараа ирж байсан бөгөөд эдийн засгийн хувьд ямар нэгэн байдлаар тогтвортой болонгуут гэр бүлээ Японд авчирч байлаа. Харин ганц бие эрчүүд нь нутагтаа буцан нутгийнхаа бүсгүйчүүдтэй гэр бүл болчихоод Японд эхнэрүүдтэйгээ буцан ирж байлаа. Мөн гэр бүл болон танилуудаараа дамжуулан Японд ирж байсан солонгосчууд маш олон байжээ. 1938 оны байдлаар Японд буй солонгосчуудын тоо 800.000-д хүрсэн байлаа.

Дэлхийн II дайны үед

Японд 1939 он гэхэд дэлхийн II дайнаас улбаатай ажиллах хүчний хомсдол үүссэн нь солонгосчуудыг Японд ажиллуулахаар дайчлах ажил албан ёсоор эхлэхэд хүргэжээ. Японы Засгийн газар эхэндээ солонгосчуудыг ажиллах товчоогоор дамжуулан дайчилж байсан бол дараа нь шууд албадлагын аргаар дайчлах болжээ. Нийтдээ 5.400.000 хүн дайчлагдсанаас 670.000 орчим нь тухайн үеийн Карафүто мужийг (Одоо Оросын газар нутаг болох Сахалин) оролцуулаад Японы эх газар луу хөдөлмөр хийхээр илгээгджээ. Японд ирсэн тэдгээр хүмүүс хүчинд автан гэр бүлээсээ тусгаарлагдаж, үйлдвэр болон нүүрсний уурхайн, цэргийн байгууламж, барилгын талбар болон нисэх онгоцны буудал, цэргийн зориулалттай хонгил барих зэрэг хүнд нөхцөлд хөдөлмөрлөж байлаа. 1939-1945 оны хооронд хатуу ширүүн харьцаа, хөдөлмөрийн хүнд нөхцөл, холбоотнуудын бөмбөгдөлтөөс болж 60.000 орчим солонгос хүн амиа алджээ. Дайны дараа Японд хөдөлмөрлөж байсан улсуудын ихэнхи нь нутаг буцсан бөгөөд зарим хэсэг нь Японд үлдсэн байна. Тэдгээр хүмүүсийн нэг хэсэг болох 43.000 хүн Япон дайнд бууж өгөхөөс өмнөхөн ЗХУ-ын цэрэгт эзлэгдээд байсан Карафүто арал дээр байсан бөгөөд тэднийг Японы эх газар, Солонгосын хойгийн алинд нь ч буцаахаас татгалзсан учир Сахалинд үлдэж, ингэснээрээ Сахалины солонгосчуудын өвөг, дээдэс болжээ. Мөн дээрхи хугацаанд Японы цэргийхэн олон тооны залуу солонгос эмэгтэйчүүдийг “тав тухын эмэгтэй” хэмээх нэрийн доор хүчээр авчирч байлаа. 1945 онд Япон нь Холбоотны хүчинд бууж өгөх үед Японд ойролцоогоор 2.300.000 орчим солонгос хүн байжээ.

Хүчээр япон нэр олгох болсон нь буюу “soshi kamei”

Япон нь Солонгосыг колоничлох хугацаандаа ялангуяа Номхон Далайн дайн дэгдсэний дараа өөрийн цэргийн хүчээ ашиглан Солонгосчуудыг бүрмөсөн Японд уусгах бодлого явуулж эхэлсэн байна.

Энэ уусгах бодлогын нэг хэсэг болгон солонгосчуудад “soshi kamei” буюу өөрсдийн солонгос нэрний оронд япон нэр авах шаардлагыг тулгаж байлаа. “Soshi kamei” нь Солонгосын гэр бүлийн уламжлалт тогтолцоог үндсээр нь өөрчилж Япон болгох зорилготой байлаа. “Soshi kamei” хэрхэн явагдсаны үр дүн өнөөг хүртэл илэрхий байгаа бөгөөд Япон дахь солонгосчуудын ихэнхи нь өдөр тутмынхаа амьдралд өөрсдийн солонгос нэрний оронд япон нэр ашигласан хэвээр байна. Гэхдээ тухайн үеийн Солонгосчууд өөрсдийн нэрний ханзыг япон дуудлагаар нь хувирган уншсанаар өөрсдийн угсаа гарал, удам судраа хадгалахыг хичээж байжээ. Жишээ нь Солонгосын хамгийн элбэг тохиолддог овгийн нэр болох “Ким”-ыг тэмдэглэдэг дүрс үсэг нь японоор “Кане” хэмээн уншигддаг учир “Ким” овогтой хүмүүс өөрсдийгөө “Канеда”, “Канеяма” гэх мэт овгийн нэрээр нэрлэх болжээ. Харин зарим солонгосчууд нь өөрсдийн япон овгоо сонгохдоо “bonkwan” буюу өөрсдийн өвөг дээдсийн үүссэн нутаг устай холбоотой овог сонгож байсан бол нэг хэсэг нь өөрсдийн гэр бүлийн түүхтэй холбоотой ханз ашигласан овог нэр зохиож байлаа.

Түр оршин суугчаас байнгын оршин суугч болсон нь:

Япон улс 1945 оны 8 сарын 15-нд дэлхийн II дайнд ялагдсанаар Японы колоничлолд байсан Солонгосчууд чөлөөлөгдсөн бөгөөд тухайн үед Японд байсан ихэнхи солонгосчууд нутаг буцсан юм. Японд байсан бүх солонгосчууд нутаг буцах нийтлэг сонирхолтой байсан нь тодорхой боловч 500000-600000 солонгосчууд өөр сонголтгүй байсан учир Японд үлджээ. Ер нь Японд байгаа солонгосчуудын ихэнхи нь хүчинд автаж ирсэн солонгосчуудын үр сад гэсэн нийтлэг ойлголт байдаг, үнэндээ цөөн тооны тийм хүмүүс байдаг ч өнөөдөр Японд байгаа солонгосчуудын дийлэнх олонхийн хувьд бол тохиромжгүй ойлголт юм. 1939-1945 оны хооронд хүчинд автаж Японд ирсэн солонгосчуудын олонхи нь дайны дараа нутаг буцсан бөгөөд өнөөгийн Зайничи солонгосчууд бол гол төлөв солонгосчуудыг хүчээр Японд авчирч эхлэхээс өмнө ажил хайж ирсэн тэдгээр хүмүүсийн үр сад юм. Хүчинд автаж Японд ирсэн солонгосчуудын хувьд Япон нь өшөө, хорсол төрүүлсэн улсаас өөр зүйлгүй байсан тиймдээ ч тэд нутаг буцахыг хүсэж байсан учир Японд үлдэх шалтгаан байхгүй байлаа. Харин өмнө нь Японд ирсэн хүмүүсийн хувьд нөхцөл байдал өөр байлаа. Японы колонийн дэглэмийн үр дүнд тэдний Солонгос дахь амьдрал үндсээрээ нурсан учир тэд Японд ирж бүхнийг шинээр эхлэх сонголт хийсэн юм. Эхэндээ тэд ганц бие цагаач ажилчид байсан бол яваандаа энэ байдал нь тэд гэр бүлээ Солонгосоос авчирч Японд суурьших болсоноор өөрчлөгдсөн. Хэдийгээр япончууд тэднийг ажлын нөхцөл болон цалин хөлсний тал дээр ялгаварлан үзэж байсан ч

амьдрахад хүрэлцээтэй байлаа. Японы дарлалаас чөлөөлөгдсөний дараа эдгээр хүмүүс ч мөн Солонгос руу буцаж болох байсан хэдий боловч тэдний хувьд гэр бүл нь Японд байсан, Солонгос руу буцаж очлоо гэхэд бүхнийг эхнээс нь эхлэнэ гэдэг бол хүнд байсан бөгөөд нутаг буцах хүсэлтэй нь зэрэгцээд тэнд очоод сайхан амьдарна гэдэг баталгаа байхгүй байсан учир энэ нь их хэцүү сонголт байжээ. Улмаар Солонгос дахь нийгэм, эдийн засгийн замбараагүй байдал мөн Солонгос улс хоёр хуваагдсан зэрэг нь Японд үлдсэн хүмүүсийн сонголтыг нь баталгаажуулж өгчээ. Дайнд ялагдсанаар Япон нь Солонгосын хойг болон Тайвань дахь зэрхэх байдлаа алдсан бөгөөд 1947 оны 05 сарын 01-ны хуулиар бол Солонгосчууд, Тайваньчуудыг гадаадын иргэд гэж үзэх болжээ. Солонгосын хойг дээр бие даасан улс байхгүй байсан тул солонгосчууд урьдчилсан байдлаар хуваагдаагүй Солонгосын хуучин нэр болох Joseon (японоор Chosen) нэрээр бүртгүүлжээ. 1948 онд Хойд болон Өмнөд Солонгосчууд тусгаар тогтнолоо тус тусдаа зарласанаар Joseon гэдэг улс оршин тогтнохоо болисон бөгөөд шинээр байгуулагдсан БНСУ-ын ЗГ нь Холбоотны хүчний дээд командлалд Зайничи Солонгосчуудын үндэс угсааны бүртгэлийг Daehan Minguk (шинэ улсын албан ёсны нэр) болгох хүсэлт гаргажээ. Үүний дараа 1950 оноос Зайничи Солонгосчуудад өөрсдийн харьяалалаа дээрх маягаар сайн дураараа бүртгүүлэхийг зөвшөөрчээ.

Японы иргэн болон гадаадын иргэний эрхийн талаархи гэрээ

Дайны дараа Японы Засгийн газар нь Зайничи Солонгосчуудын японы иргэн болон гадаадын иргэн гэсэн эрхийн аль алиныг нь үгүйсгэж байв. Жишээлбэл, дайны дараа Японд олон газар солонгос сургуулиуд байгуулагдаж байсан бөгөөд тэдгээрийг хүүхдүүд нь Солонгосын түүх болон хэл соёлыг ирээдүйд Солонгостоо буцах бэлтгэл болгон сурахыг хүсэж байсан эцэг, эхчүүд байгуулжээ. Гэвч Японы албан тушаалтнууд хэрэв тэдгээр хүүхдүүд японы иргэд юм бол гадаадын иргэд мэт боловсрол эзэмших нь утгагүй гэж үзэн тэдгээр сургуулиудыг хааж байлаа. Нөгөө талаар Японы засгийн газар 1945 оны 12-р сард Зайничи солонгосчуудын япон иргэдийн адил санал өгөх эрхийг нь түдгэлзүүлжээ. Тэр байтугай 1952 оны 04 сарын 28-нд хүчин төгөлдөр болсон Сан Францискогийн Энхтайвны Гэрээний дараа ч Японы Засгийн газар Зайничи солонгосчуудыг эх оронд нь буцаахгүй хэвээр байсан бөгөөд улмаар Японы Засгийн газар тэдний Японы харьяалалыг түдгэлзүүлжээ. Түүнээс гадна Японы Засгийн газар дайнд оролцсон ахмад дайчид болон амь үрэгдэгсдийн гэр бүлд нөхөн олговор олгосон боловч дайны үед хүчинд автан япон цэргийн талд тулалдаж байсан солонгосын ахмад дайчид, тэдний гэр бүлийн алинд

нь ч нөхөн олговор олгоогүй байна. Үүний үндэс нь тэд бол дайны үед японы иргэд байсан хэдий ч хууль батлагдах үед япон иргэд биш болсон байсан гэж үзжээ. Гэтэл дайны үед Японы армид дайчлагдсан, Холбоотны хүчний олзлогсолтой хэрцгий харьцах тушаалтай байсан олон солонгосчууд дайны дараа цэргийн гэмт хэрэгтэн мэт шүүгдэж, тэр байтугай тэдний японы харьяалалыг түдгэлзүүлсэнийх нь дараа ч дээрхи маягаар шүүгдэж, цаазлуулжээ.

Mindan болон Chongryon

Солонгосын хойг хоёр хуваагдсан явдал нь Япон дахь солонгосчуудыг мөн хоёр хуваагдахад хүргэжээ. Өмнөд Солонгосын талыг баримтлагч Mindan буюу Япон дахь солонгос иргэдийн холбоо нь 1946 оны 10 сарын 03-нд Токио хотноо, Социалист үзэл суртлыг баримтлагч Солонгос иргэдийн үндсэн байгууллага болох Choren-оос (Япон дахь солонгосчуудын лиг) салбарлан байгуулагджээ. Тэдний үйл ажилгааны үндсэн чиглэлүүд нь:

1. Япон дахь Солонгосчуудын соёлын хөгжил
2. Тэдний хууль ёсны эрхийг хамгаалах
3. Тэдний нийгмийн хангамж

4. Эдийн засгийн хөгжил болон Солонгосыг энх тайвны замаар нэгтгэх гэсэн байдаг байна. Өнөөдөр Mindan нь хагас сая гишүүнтэй том байгууллага болон өргөжжээ. XXI зуунд орсоноор Zainichi солонгосчуудын нийгмийн төв нь 2-догч, 3-дагч үе рүүгээ шилжсэн бөгөөд өөрчлөгдөж буй шаардлагад нийцэн шинэчлэгдэх шаардлагатай болсон юм. Өнөөдөр Mindan-ы нийгмийн хөдөлгөөнүүд нь “эсэргүүцэл болон буруутган үзэх”-ээс “энхтайван болон зохицон амьдрах” болон өөрчлөгджээ.

- 1952 оны таван сарын үймээний дараа Хойд Солонгосын талыг баримтлагч байгууллага хууль ёсны болсон боловч, олон төрлийн нэрээр дахин дахин байгуулагдсаар эцэст нь 1955 онд Chongryon буюу “Япон дахь Солонгосчуудын Ерөнхий Холбоо” болон байгуулагджээ. Энэ байгууллага нь социалист үзэл суртал, Хойд Солонгосын талыг баримталж байснаараа Хойд Солонгосын Засгийн газрын зүгээс идэвхитэй санхүүгийн дэмжлэг болон зөвлөгөөг авч байлаа. Зайничи Солонгосчуудын хоёр байгууллагаас Хойд Солонгосын талыг баримтлагч Chongryon нь Солонгосын угсаатны асуудалтай холбогдох зүйлүүд дээр илүү цэргийн байр сууринаас ханддаг байна. Тэдний баримталдаг бодлогын чиглэлүүд:

1. Японыг хамарсан бүх хичээл нь солонгос хэл дээр явагддаг солонгос үндэсний 60 гаруй сургуулийн үйл ажиллагаа. Үйл ажиллагаандаа Хойд Солонгосын үзэл баримтлалыг хатуу баримталдаг

учир анхандаа Хойд Солонгосын Засгийн газраас санхүүжүүлж байсан бөгөөд тэдгээр олон нийт, эцэг эхчүүд, сурагчдын аль алиных нь зүгээс заримдаа шүүмжлэлд өртдөг.

2. Гишүүдийнхээ японы иргэншил авахыг явдлыг буруушаах

3. Гишүүдийнхээ япон иргэдтэй гэр бүл болох явдлыг буруушаах

4. Chongryon-ы холбоо бүхий бизнес болон банкууд нь Зайничи солонгосчуудыг шаардлагатай ажлын байраар хангаж, үйлчилгээ, нийгмийн даатгалын сүлжээнд хамруулах

5. Тэдний хувьд японы нийгэмд уусгах зорилготой, хүлээж авч болмооргүй оролдлого мэт харагдаж байсан Зайничи Солонгосчуудын японы сонгуульд оролцох, санал өгөх эрхийг эсэргүүцэх

6. 1950-иад оны сүүлээр өрнөсөн “нутаг буцах хөдөлгөөн” буюу социалистуудын уриалж байснаар “Газар дээрхи диваажин – Хойд Солонгос” руу буцах хөдөлгөөн.

1970-аад оны байдлаар Chongryon нь давамгайллагч Зайничи бүлэг байсан бөгөөд өнөөдөр ч улс төрийн хувьд илүү чухал үүрэгтэй хэвээр байна. Гэхдээ Хойд болон Өмнөд Солонгосын улс төр болон эдийн засгийн нөхцөл байдлын ялгаа нь Өмнөд Солонгосын талыг баримтлагч Mindan-ыг илүү том, улс төрийн хувьд илүү эргэлзээ багатай бүлэг болгожээ. Зайничи Солонгосчуудын 65 хувь нь одоо Mindan-ыг дэмжих болжээ.

Зайничи Солонгосчуудыг нутаг буцаах хөдөлгөөн

- Японы Улаан Загалмайн Нийгэмлэгийн зохион байгуулсан Зайничи Солонгосчуудыг эх оронд нь буцаах хөдөлгөөн албан ёсоор 1956 оны эхээр Японы Засгийн газрын дэмжлэгийг авч эхэлсэн бол Хойд Солонгосын санхүүжүүлсэн нутаг буцаах хөдөлгөөн 1959 онд албан ёсоор эхэлжээ. Японы Засгийн газрын зүгээс энэ нутаг буцаах хөдөлгөөнийг зөвхөн эдийн засгийн хямралын үед ажиллах хүчнийг бууруулж байна гэдэг утгаар нь биш мөн “коммунист” эсвэл “хорлон сүйтгэгчид” гэж нэрлэгддэг үндэсний цөөнхүүд улсаас нь гарч байсан учир дэмжиж байсан юм. Зайничи Солонгосчуудын 97 хувь нь Солонгосын хойгийн өмнөд хэсгээс гаралтай гэдэг баримтыг үл хамааран анхандаа нутаг буцахад Хойд Солонгос нь Өмнөдөөсөө илүү таатай нутаг байсан бөгөөд улмаар Хойд Солонгос руу буцагчдын цөөн тооны цуваа 1984 оны сүүл хүртэл үргэлжилсэн ч, нүүн очигсод Хойд Солонгост ямар хүнд нөхцөлтэй тулгарч байгаа талаархи мэдээлэл, улмаар 1965 онд Япон-Өмнөд Солонгосын харилцаа тогтворжсон зэрэгтэй холбоотойгоор Хойд Солонгос руу буцах явдал огцом буурсан байна. Нийтдээ 93340 хүн “Нутаг буцах хөтөлбөр”-ийн дагуу Хойд Солонгос руу нүүсэн бөгөөд тэдний 6000 орчим нь солонгос эхнэр, нөхрөө даган явсан япон хүмүүс байжээ. Дараа нь

шилжин суурьшигчдын 100 орчим нь Хойд Солонгосоос оргосон бөгөөд тэднээс хамгийн алдартай нь сүүлд өөрийнхөө тухай “Гхеньяны шилэн хорго” хэмээх ном бичсэн Kang Chol Hwan юм. Хэдийгээр нутаг буцагсдын ихэнхи нь ерөнхийдөө нийгмийн ялгаварлан гадуурхах үзэл болон улс төрийн дарамттай тулгарч байсан ч зарим нь Хойд Солонгосын ЗГ-ын удирдах болон төрийн томоохон албан тушаалд хүрч чадаж байсан байна. Жишээлбэл, сүүлд Япон руу оргож ирсэн Кэнки Аяома хэмээх япон нэртэй нэгэн зайничи солонгос хүн Бээжинд Хойд Солонгосын талын тагнуулаар ажиллаж байжээ.

Зайничи солонгосчуудын бүртгэлийн асуудал

- Японд өмнө нь гадаадын иргэдийг бүртгэх ажиллагааны нэг хэсэг болгон хурууны хээ авах аргыг ашигладаг байсан бөгөөд энэ нь байнга хэл амны бай болж ялангуяа солонгосчуудын зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байсан юм. Олон жилийн хөдөлгөөний үр дүнд энэ шаардлага нь “Тусгай байнга оршин суугчид - Токүбэцү Эйжүшя” хэмээх статустай зайничи солонгосчууд мэтийн хүмүүсийн хувьд 1992 оноос хүчингүй болжээ. Гэхдээ Mindan нь гадаадын иргэд өөрсдийн бүртгэлийн картыг байнга биедээ авч явах ёстой гэсэн шаардлагыг устгаагүйд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлдэг байна.

Санал өгөх эрх болон Засгийн газарт хөдөлмөр эрхлэх эрхийн төлөөх тэмцэл

- Японы иргэншлийг аваагүй Японд удаан хугацаагаар оршин сууж буй Солонгос гаралтай оршин суугчид өнөөдөр “Токүбэцү Эйжүшя - Тусгай байнга оршин суугчид” гэсэн хууль ёсны статустай бөгөөд тэдэнд бусад гадаад иргэдтэй харьцуулахад тусгай эрх болон давуу эрх нь ялангуяа хилээр дахин нэвтрэх, албадан гаргах дүрэм зэрэг дээр олгогдсон байдаг байна. Эдгээр давуу эрхийг анх 1965 онд зөвхөн Өмнөд Солонгосын харъяалалтай оршин суугчдад олгосон боловч 1991 онд өөрсдийн Joseon харъяалалыг хадгалж үлдсэн хүмүүст болон өөрчлөгджээ. Хэдэн арван жилийн турш Зайничи солонгосчууд Японы иргэн болохгүй гэхдээ өөрсдийн япон иргэний эрхийг дахин олж авах тал дээр хөдөлгөөнт ажил өрнүүлж байна. Нийгмийн тэтгэмжинд хамрагдах эрхийг олгосон хууль 1954 онд батлагдсан бөгөөд дараагаар нь Үндэсний эрүүл мэндийн даатгалд (1960), Улсын тэтгэвэрт (1980) хамрагдах хуулиуд тус тус батлагджээ. Гэхдээ эдгээр тэтгэмжүүдийн зарим нь хууль ёсонд нийцэж байгаа эсэхэд эргэлзээ байдаг бөгөөд учир нь Public Assistance Law-д нийгмийн тэтгэмжийг зөвхөн Японы харъяатад олгоно гэж заасан байдаг ажээ. Түүнээс гадна мөн Зайничи солонгосчуудад Засгийн газарт ажил эрхлэх боломж олгох, өмнө нь

зөвхөн Япон иргэдэд нээлттэй байсан эрх болох сонгуульд оролцох эрхийг олгох талаар хөдөлгөөн өрнүүлж байсан юм. 1992 оноос хойш мужийн засаг захиргаа, хотын захиргааны чуулган, хотын дарга болон мужийн захирагчийн сонгуульд санал өгдөг эрхийн төлөө Өмнөд Солонгосын ЗГ-ын дэмжлэгтэйгээр хөдөлгөөн өрнүүлэх болжээ. Үүний үр дүнд 1997 онд Кавасаки хотын захиргаа нь солонгос үндэстнийг авч ажиллуулсан анхны хотын захиргаа болжээ. Үүний дараагаар Осака, Нара, Канагава хотууд нь байнга оршин суугч гадаадын иргэдийн санал өгөх эрхийг нь хангаж өгчээ.

Гэсэн хэдий ч зарим улс төрийн намуудын батлах гэсэн хэдэн оролдлогоос үл хамааран энэ асуудлын шийдэлд Японы парламент хүрч чадаагүй байгаа бөгөөд Японы иргэншлийг аваагүй тэдгээр хүмүүст санал өгөх эрх олгохыг эсэргүүцсэн олон нийтийн болон улс төрийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгараад байгаа юм. Нөгөө талаас Chongryon нь зайничи солонгосчуудад Японы улс төрд оролцох эрх олгох нь зайничи солонгосчуудыг японы нийгэмд уусгаж улмаар тэд нар Солонгос угсаатны онцлогоо алдана гэдэг үүднээс эсэргүүцэж байгаа юм.

Солонгос сургуулиуд

Японд буй Зайничи солонгосчуудын сургуулиудын ихэнхийг Пхеньяны талыг баримтлагч Chongryon хариуцдаг бөгөөд нэг цэцэрлэг, нэг их сургуулийг оролцуулаад нийтдээ 218 солонгос сургуультай юм байна. Mindan ч мөн хэд хэдэн сургуультай боловч тэд нь одоо бараг л оршин тогтнохоо больж байгаа юм.

Chongryon-ы сургуульд үзэж буй бүх хичээл, багш сурагчдын хоорондын харилцан яриа нь солонгос хэл дээр явагддаг. Тэд Хойд Солонгосын социалист үзэл суртал болон Ким Ир Сен, Ким Чен Ир д үнэнч байх явдлыг идэвхитэйгээр дэмжиж, үйл ажиллагааныхаа гол чиг шугам болгодог байна. Тэд Японы үндэсний сургалтын хөтөлбөрийг үйл ажиллагаандаа баримталдаггүй учир хууль дүрмэнд захирагддаг энгийн сургуулиудийн ангилалд багтдаггүй байна. Тэдний гол хүндрэлүүдийнх нь нэг бол санхүүжилт бөгөөд эдгээр сургуульд анх байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхлэхдээ Хойд Солонгосын Засгийн газрын дэмжлэгийг авч байсан бол одоо тэр мөнгө нь багасч, сурагчдын тоо цөөрсөн учир олон сургууль нь санхүүгийн хүндрэлтэй тулгараад байна. Ийм учраас тэд Японы Засгийн газарт Chongryon-ы угсаатны сургуулиудыг японы энгийн сургуулиудын нэг адил санхүүжүүлээч гэдэг хүсэлт гаргасан ч Засгийн газар уг саналыг олон нийтийн биш этгээд нь боловсролд зориулсан олон нийтийн хөрөнгийг зарцуулах эрхгүй гэсэн Үндсэн Хуулийн 89 заалтыг үндэслэн татгалзжээ. Гэхдээ бодит байдал дээр сургуулиуд нь зарим талаар орон

нутгийн засаг захиргаанаас санхүүжигдэж байсан бөгөөд гэхдээ уг санхүүжилт 89-р заалтыг илэрхий зөрчихөөс зайлсхийсэн утгаараа сурагчдын гэр бүлээс төлж буй тусгай хандив хэлбэрээр ирж байна. Энэ нь мөн Японы энгийн сургуулиудаас бага байгаа юм. Гэхдээ өнөөдөр ихэнхи Зайничи Солонгосчууд хүүхдүүдээ Япон сургуульд сургах болсонтой зэрэгцээд Chongryon-ы сургуульд боловсрол эзэмшигч сурагчдын тоо эрс буурсан, санхүүгийн хүндрэл зэрэгтэй холбоотойгоор уг сургалтын системийн бүхэлдээ оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй байгаа юм.

Бас нэг асуудал бол элсэлтийн шалгалт өгч, улсын сургуульд орохыг хүсч байгаа энгийн сургууль төгссөөгүй хүүхдүүдийг шалгаруулдаг дайкен буюу Ахлах Сургуулийн Түвшин Тогтоох Шалгалт юм. Саяхныг хүртэл албан ёсны боловсрол эзэмшсэн тэдгээр хүүхдүүд л уг шалгалтанд орох эрхтэй байсан бөгөөд энэ нь угсаатны сургууль төгссөн хүүхдүүд уг шалгалтанд орохын тулд нэмэлт бэлтгэл хийх ёстой гэсэн үг байлаа. Гэвч энэ нь урьдын адил япон биш ахлах сургууль төгсөгчид дайкен шалгалт өгөх шаардлагатай гэсэн үг байсан учир зайничи солонгосчууд сэтгэл хангалуун бус байлаа.

2003 онд Японы Боловсролын Яам хятад сургуулиуд, Минданы солонгос сургуулиуд, барууны орнуудын нэгдэн байгуулсан болон АНУ, Их Британий магадлан итгэмжилсэн олон улсын сургуулиудын төгсөгчдөөс уг шалгалтыг авах шаардлагыг цуцалжээ.

Өнөөдөр Зайничи солонгосчууд нь олон жилийн тууштай тэмцлийн үр дүнд өөрсдийн тогтвортой оршин тогтнохуйг бий болгосон бөгөөд Mindan, Chongryon мэтийн зайничи байгууллагуудын идэвхитэй үйл ажиллагаа, бусад үндэсний цөөнхүүдийн дэмжлэгтэйгээр япончуудын зайничи солонгосчуудад хандах нийгмийн нөхцлийг сайжруулж чадсан байна.

Ашигласан материал

1. Koreans in Japan: Past and Present by Fukuoak Yasunori *Saitama University Review* Vol.31, No.1
2. The Self-Identities of *Zainichi* Koreans by Jin Saeng So
3. www.mindan.org
4. www.chongryon.com
5. www.han.org
6. en.wikipedia.org/wiki/Zainichi_Korean